



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/22

Чингис хот

**Шийтгэвэр, торгуулийн хуудсыг  
устгах комисс томилох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 260 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 1993 оны 112 дугаар тушаал хүчингүй болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд хэрэглэгдэж байсан шийтгэвэр, торгуулийн хуудсыг устгах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Цэцэгмаа	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн
Гишүүд:	Н.Нарантуяа	-Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	С.Энхбаяр	-“Хэнтий нийтлэг үйлчилгээ” ОНӨГ-ын жижүүр
	Г.Ганбаяр	-“Хэнтий нийтлэг үйлчилгээ” ОНӨГ-ын жолооч

2. Өмнөх онуудад хэрэглэж байсан шийтгэвэр, торгуулийн хуудсыг жагсаалтын дагуу устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг комиссын дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР